МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.07.01 № 02/1945

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилт, зорилго, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгон 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг биелэлтийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 13 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР

ATA14031 9129294
9024120060

1508 09 1362

## Засгийн газрын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүрээнд тусгагдсан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн биелэлт

Огноо: 2025.06.30

| Д/д | Зорилго | Зорилт | Төсөл, арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2024 оны суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь | Өссөн дүн | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **1.1. Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт** | | | | | | | | | | | |
| 1 | 1.1.4. Ногоон - ухаалаг хот | 1.1.4.3. Улаанбаатар хотын төв, хүн ам ихээр төвлөрсөн бүсүүдээр аюултай ачаа тээвэрлэхгүй байх зохицуулалтыг хийнэ. | 50. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд газрын тосны бүтээгдэхүүний ашиглалт, хадгалалт, борлуулалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тусгаж, мөрдүүлэх | 2025-2028 | Хууль зүй, дотоод хэргийн яам | 0 | - | Монгол Улсын Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт "Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм" болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар зохицуулсан байдаг. Үүний дагуу "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм"-д Зам, тээвэр хөгжлийн сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн "MNS 4978:2025 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага"-ыг 2025.02.05-ны өдөр Стандарт, хэмжил зүйн газрын даргын С/05 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжилтэд холбогдох байгууллагууд хяналт тавьж ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тус яамны зүгээс холбогдох байгууллагуудтай тухай бүр хамтран ажиллах | Х.Б | Х.Б | Х.Б |
| **1.2. Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот** | | | | | | | | | | | |
| 2 | 1.2.1. Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын дэд бүтэц | 1.2.1.3. Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгана. | 79. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 20 | Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн 139 дүгээр тогтоолоор Багануурын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд зориулан 635 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Паркийн хүрээнд үйлдвэрийн нэгжүүдийг барьж байгуулах, аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хамтран ажиллах, үйлдвэрлэл явуулахад төрөөс дэмжлэг үзүүлж, таатай орчин бүрдүүлэх бодлого баримталж байна. Паркийн удирдлагын компани болох "Эрдэнэс ҮТП" ХХК нь Багануур ҮТП-ийн үйлдвэрийн бүсэд хэрэгжүүлэх төслийн санал ирүүлэх урилга, хүсэлтийг /2025.05.12-05.23 хүртэл/ аж ахуйн нэгжүүдэд нээлттэй зарлаад байна. ҮТП-ийн хүрээнд цахилгаан эрчим хүч болон шаардлагатай дэд бүтцийг нэгдсэн байдлаар холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байна. | 30% | 30% | 30% |
| 3 | | | 80. Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 10 | Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах чиглэлээр Төр, хувийн хэвшлийг дэмжих тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажилласан. Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран 2025.04.28-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж "Налайх ҮТП", "Багануур ҮТП", "Багахангай ҮТП"-ийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон. Багахангай ҮТП-ийн хүрээнд 56 га газрын нэгж талбарыг тодорхойлж баталгаажуулаад байна. | 10 | 10 | 10 |
| 4 | | | 81. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 20 | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |
| **1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил** | | | | | | | | | | | |
| 5 | 1.3.1. Хангайн бүс - "Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс" | 1.3.1.2. Шинэ Хархорум хотын усны хэрэгцээг хангах бүтээн байгуулалтыг эхлүүлж, Орхон голд урсцын тохиргоо хийж, усан хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ. | 97. "Шинэ Хархорум" хотын хүн амын унд, ахуйн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгааг хийх | 2025 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | 0 | - | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |
| 6 | 1.3.2. Баруун бүс - "Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс" | 1.3.2.2. Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож эргэлтэд оруулна. | 104. Ордын нөөцийг нэмэлт хайгуул хийж тогтоон батлуулж, орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, хөрөнгө оруулалтыг | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 0 | Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө батлагдан хайгуулын ажил хийгдэж байна. | 10 | 10 | 10 |
| 7 | | 1.3.2.3. Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан дэвшилтэт технологийн шохойн үйлдвэр, Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулахыг төр, хувийн хэвшлийн хүрээнд хамтран хэрэгжүүлнэ. | 105. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээг хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулж, парк, цогцолборын үйл ажиллагааг эхлүүлэх | 2025 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 0 | 10 | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1.3.3. Хойд бүс-"Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс" | 1.3.3.2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна. | 111. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, технологийн түвшний үнэлгээ хийх, үндсэн болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулж, батлуулах | 2025 | АҮЭБЯ | 0 | 10 | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762,255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгагдсан Зэсийн баяжмал, хайлуулах боловсруулах үйлдвэрийн 2022 онд батлагдсан ТЭЗҮ-д Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хүхэр агуулсан хийг нүүрсээр ангижруулж элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр ТЭЗҮ-ийн тодотгож, холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлэх хүсэлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас 2025.03.12-ны өдөр ирүүлсний дагуу АҮЭБЯ-ны Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл түүний тодотголд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн 2025.03.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж ТЭЗҮ-ийн тодотголыг буцаасан.<br>Зэсийн баяжмал, хайлуулах боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын техникийн даалгаварыг боловсруулж байгаа бөгөөд | 10 | 10 | 10 |
| 9 | | | 112. Үйлдвэрийн үндсэн барилга, байгууламж, агуулах барих болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаар | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 0 | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |
| 10 | 1.3.4. Говийн бүс - "Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс" | 1.3.4.1. "Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолбор барих ажлыг эхлүүлнэ. | 117. Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн үндсэн зураг төсөв, технологийн түвшний үнэлгээ боловсруулж, батлуулах | 2025 | АҮЭБЯ | 0 | 10 | Засгийн газрын 2024 оны 204 дүгээр тогтоолоор "Үйлдвэрлэл, технологийн парк эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт"-ыг баталсан. Уг жагсаалтад Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт коксын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, кокс, хагас кокс, коксын давирхай, коксын зуухны хий, нүүрсний давирхай зэрэг кокс-химийн бүтээгдэхүүний нэр төрөл тусгагдсан. Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Кокс-химийн цогцолбор барьж, Дарханы гангийн үйлдвэр болон ҮТП-ийн цогцолборт байгуулагдах бусад үйлдвэрүүдийг анхан шатны боловсруулалт хийгдсэн түүхий эдээр хангах, бусад ҮТП-ийн төслүүдтэй түүхий эд, бүтээгдэхүүний холбоогоороо нягт уялдан, гинжин хэлхээний зарчмаар хөгжүүлэхээр төлөвлөж байна. Кокс-хиймийн үйлдвэр нь жилд 1.2 сая тн нүүрс боловсруулж, кокс, коксын хий, давирхай, аммонийн сульфат зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Тавантолгой ҮТП-ийн хүрээнд баригдах Кокс-эрчим хүчний үйлдвэрийн 2 техник, эдийн засгийн үндэслэлийг Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж батлаад байна Мөн Тавантолгойн ҮТП-ийн зориулалттай | 100% | 90% | 100 |
| 11 | | 1.3.4.2. Тавантолгойн бүлэг ордыг түшиглэн хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн парк, "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулахыг төр, хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлнэ. | 119. Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркт баригдах коксын үйлдвэр (600.0 мян.тн/жил)-ийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх | 2025 | АҮЭБЯ | 0 | 60 | "Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК)-ийн хэрэгжүүлж буй "Алтанширээт үйдвэрлэл, технологийн парийн хүрээнд 1-1.5 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэр, 1.0-2.0 сая тонны хүчин чадалтай коксын үйлдвэр байгуулагдахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй "Инфинити спэйс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Билэгсайхан нар "Татвар төлөх хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 183 нэр төрлийн 780 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн 39.0 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 81.9 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилээр сунгаж, татвар | 65% | 5 | 65 |
| 12 | | | 120. Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркт цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх (20.0 МВт.цаг/тн) | 2025 | АҮЭБЯ | 0 | - | Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК)-ийн хэрэгжүүлж буй "Алтанширээт үйдвэрлэл, технологийн парийн хүрээнд баригдах 20.0 мВт.цаг/тн хүчин чадалтай цахилгаан станц барих төслөө 2025 онд багтаан эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 13 | | | 123. Гэрэлтговь үйлдвэрлэл, технологийн паркт байгуулах коксын үйлдвэр (500.0 мян.тн)-ийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 30 | "Си Өү Эй Эл" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд жилд 3 сая тонн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, жилд 600 мянган тонн металлургийн кокс үйлдвэрлэх хүчин чадалтай кокс, эрчим хүчний үйлдвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй "Си Өү Эй Эл" ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Будгэрэл нар "Татвар төлөх хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 1915 нэр төрлийн бараа материалаас 2025 оны 06 дугаар сарын байдлаар 231 нэр төрлийн бараа материалыг 95,941 сая төгрөгөөр импортлон авч Зүүнбаян-Ханги хүртэлх 22.6 км салбар төмөр зам, 3 сая тонны хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын үндсэн бүтцийн ажил болон өтгөрүүлэгчийн барилга, тоног төхөөрөмжийн угсралт, цахилгаан холболт, ачилт буулгалтын талбай, нүүрсний | 30% | 30% | 30% |
| 14 | | | 124. Гэрэлтговь үйлдвэрлэл, технологийн паркт цахилгаан станц байгуулах төсөл хэрэгжүүлэх (49.0 сая.кВт/цаг) | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | - | "Си Өү Эй Эл" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркт байгуулах 600 мянган тонн хүчин чадалтай металлургийн коксын үйлдвэрээс гарах хаягдал дулааныг боловсруулж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станцыг байгуулахаар төлөвлөн "Сайншанд-Айлбаян" 155 км урт 110 кВт цахилгаан хангамжийг паркийн хэрэглээнд нийцүүлэн өргөтгөх ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 32%-ийн гүйцэтгэлтэй байна. Хугацаа болоогүй. | 30% | 30% | 30% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 1.3.5. Төвийн бүс- "Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс" | 1.3.5.2. Дархан-Сэлэнгийн бүс нутагт металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. | 129. Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх | 2025-2027 | АҮЭБЯ | 0 | - | 1.Дархан-Сэлэнгийн бүс нутагт Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлж болохуйц 10 байршлыг судлан "Энх тал" зөрлөгийн дэргэдэх талбайд байгуулсан тохиолдолд үүсэх хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Инженер-Геологийн урьдчилсан судалгааны ажлыг тухайн газарт хийж гүйцэтгээд байна. Энэхүү судалгааны ажлын үр дүнд дээрх газар Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд онцгой хүндрэл бэрхшээл байхгүй болох нь тогтоогдсон. Цаашид тус байршлын дэд бүтцийн боломж, өртөө, зөрлөг байгуулах боломж зэргийг холбогдох байгууллага болох Зам тээврийн хөгжлийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр эцсийн координатыг тодорхойлж 2025 оны 2-р улиралд багтаан газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар ажиллаж байна.<br>2.Гангийн цогцолборын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан бэлэн болсон. Гэвч төслийн хүчин чадлын тухайд боломжит хөрөнгө оруулагчтай хамтран тогтоох шаардлага байгаа тул тендер сонгон шалгаруулалтыг түр хугацаанд хойшлуулаад байна. 2025 оны 2-р улиралд багтаан төслийн стратегийн хамтрагч, түншийг сонгон ЗГ-т танилцуулах ба ингэснээр ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах боломж бүрдэнэ. 2025 оны 4-р улиралд багтаан ТЭЗҮ-ийг АҮЭБЯ-ний дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр батлуулахаар төлөвлөж байна.<br>3."Эрдэнэс Монгол" ХХК-ийн зүгээс Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтад хамтран ажиллах боломжит 9 улсын 35 компанид Гадаад харилцааны яамаар дамжуулан хүсэлт хүргүүлсэн ба 2025 оны 04-р сарын 30-аар эцэслэн санал авсан. Одоогийн байдлаар 2 улсын 9 компани гангийн төсөл дээр хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. | 10% | 10% | 10% |
| 16 | 1.3.6. Зүүн бүс - "Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс" | 1.3.6.3. Зүүн бүсийг Говийн бүстэй интеграцчилан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. | 140. "Пиролиз, эрчим хүчний үйлдвэр"-ийн төслийг хэрэгжүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | 4.[illegible] "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс УТП" ХХК [illegible]<br>Тавантолгойн ордыг түшиглэн барих туршилтын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зардлыг санхүүжүүлэх хүсэлтийг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд байна."Эрдэнэс УТП" ХХК нь БНХАУ-ын Шинжлэх ухааны академийн Нүүрс-Химийн хүрээлэнд Багануур уурхайн 200 кг төлөөлөх чанар бүхий дээжийг бэлтгэн хүргүүлж, пиролизийн шинжилгээ хийлгэж дүгнэлтийг хүлээж авсан. Багануур үйлдвэрлэл технологийн паркийг Багануурын уурхайн залгаа 122 га болон 513 га талбай бүхий нийт 635 га газарт байгуулах талаар санал боловсруулж Багануурын үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар 635 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, 2025 оны 02-р сарын 26-ны өдөр газрын асуудлыг Нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлж дэмжүүлсэн. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан Тавантолгой, Багануурын нүүрсний төслийн мэргэжлийн ажлын хэсэг технологийн дүгнэлт, зөвлөмж гаргасны дагуу Кокс пиролизийн үйлдвэрийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, 2024 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр БНХАУ-ын "Сиден Инженеринг" ХХК шалгараад байна. Мөн БНХАУ-д нүүрс пиролизийн үйлдвэрийн бүрэн үйлдвэрлэлийн туршилт хийлгэхээр МУШУТИС-ийн Уул уурхайн | 10% | 10% | 10% |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **2.4. Баялагтаа эзэн монгол хүн** | | | | | | | | | | | |
| 17 | 2.4.2. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл | 2.4.2.4. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх гол нэр төрлийн материал болох ган туйван, цемент, хавтгай шилийг эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэж, импортыг бууруулна. | 449. Эх орны эрдэс түүхий эд /шохойн чулуу/-ээр дотооддоо үйлдвэрлэж буй цемент, шохойн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж, үйлдвэрлэлийн ээлж хувийг нэмэгдүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 80 | "Вестерн Холд" ХХК-ийн хэрэгжүүлж буй Ховд үйлдвэрлэл, технологийн паркт байгуулагдах "Ховд эко цементийн үйлдвэр"-ийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж хүлээн авахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд "Ховд" ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг яамны дэргэдэх Паркийн зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Төслийн гүйцэтгэл-70% | 80 | 70 | 80 |
| 18 | | 2.4.2.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 452. Цементийн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжийг дэмжих | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | - | "Хөтөл" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах шохой шатаах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Булжих минерал майнинг" ХХК боловсруулж ЭБМЗ-өөр 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Т/23-09-08 дугаар дүгнэлтээр батлагдсан. "Урьдчилсан халаагчтай эргэх зуух бүхий технологитой жилд 100 мян.тн хүчин чадалтай шохойн үйлдвэр барих" тендерийн гүйцэтгэгчийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгчээр "Сижен инженерчлэл" ХХК шалгарсан өнөөдрийн байдлаар гүйцэтгэлийн ерөнхий төлөвлөгөө болон топо зураг боловсруулагдсан, архитектур төлөвлөлтийн зургын даалгавар авах хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Мөн мастер төлөвлөгөө боловсруулагдсан ба гүйцэтгэгчийн зүгээс 2025 оны 05 дугаар сард багтаан танилцуулсан. Үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж хүлээн авахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд "Хөтөл" ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг яамны дэргэдэх Паркийн зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн [illegible] | 30% | 30% | 30% |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын орчин** | | | | | | | | | | | |
| 19 | 3.2.2. Бизнес, хөрөнгө | 3.2.2.15. Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг | 552. Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх | 2025 | Эдийн засаг, хөгжлийн яам | 0 | 10 | Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад бий болсон агуулга багатай хүдэр, ашигт малтмалын овоолгыг баяжуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортод гаргах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэхээр МУ-ын Засгийн газрын дугаар 275 тоот Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол 2025 оны 05 дугаар сарын 28 өдөр батлагдан гарсан. | 80% | 70% | 70% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 3.2.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин | нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ. | 553. Тохирлын үнэлгээний байгууллагуудыг дэмжиж, хөгжүүлэх | 2025-2028 | Шадар сайдын Ажлын алба (Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн) | 0 | 18 | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |
| | | | | | **3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал** | | | | | | |
| 21 | | 3.3.1.1. Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ. | 554. Баяжуулах, боловсруулах үйлдвэрт бүрэн чадлаар ажиллах шинэ систем, инновац нэвтрүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 0 | Хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 22 | | | 555. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажлыг гүйцэтгэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 4.4 | Өмнөд Монголын зарим хэсгийг хамарсан Агаарын геофизик-2024 төслийг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын 2 дахь заалтын дагуу төслийн 2025 оны төсөл, төсвийг ЭБМЗ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн УТХ-02-01 дүгнэлт гарсан. Дүгнэлтийг үндэслэн төслийн төсвийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/135 дугаар тушаалаар баталсан. Төслийн хүрээнд 2 онгоц Монголд ирсэн бөгөөд хэмжилтийн нислэгийн бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд Баруун Монголын зарим талбайд буюу 136 мянган км2 талбайд Агаарын геофизик-2025 төслийг шинээр эхлүүлэхээр тусгасан. Төслийн гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагаа | 50 | 10% | 50 |
| 23 | | | 556. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | Улсын төсөв гүйцэтгэл 597.6 санхүүжилт 468.3 | 47 | Геологийн 1:50 000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн Хайрхан Овоо-50, Их Хараат уул-50, Оорцог уул-50, Зангат-50, Модот толгой-50, Алаг баян-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн шаардлага хангасан тухай дүгнэлт гарсан. Дүгнэлтэд үндэслэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/110-115 дугаар тушаалаар хүлээн авсан. Үүний үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийн 27407.85 км2 талбайг зураглал болон ерөнхий эрэлд хамруулсан. Үүнд улсын төсвөөс 7,24 тэрбум төгрөгийг зарцуулсан. Мөн 2025 оноос 9 төслийг шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн | 50 | 10% | 50 |
| 24 | | | 557. 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 0 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд Шинэ Хархорум хотын суурьшлын бүс буюу геологийн 1:25 000-ны масштабын гео-орчин болон геохимийн цогцолбор судалгааг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБ-ын яамны ТНБДаргаар батлуулсан бөгөөд гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай хуулийн | 50 | 50 | 50 |
| 25 | | | 559. Геологийн тектоник, структур, инженер-геологи, гидрогеологийн зургууд зохиох болон бусад сэдэвчилсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 7 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд Тектоник-2025, Гидрогеологи-2025, Инженер геологи-2025 гэсэн сэдэвчилсэн 3 төслийг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБ-ын яамны ТНБДаргаар батлуулсан бөгөөд гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, | 50 | 10 | 50 |
| 26 | | 3.3.1.2. Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ. | 560. Гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан үр ашигтай геологийн шинжлэх ухааны судалгаа хийх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 1 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд Төв-Ази болон зэргэлдээх бүсийн геологийн төслийг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБ-ын яамны ТНБДаргаар батлуулсан бөгөөд гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай хуулийн | 50 | 10% | 50 |
| 27 | | | 561. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн геологийн суурь судалгаа болон эрлийн ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгч баялгийн хэмжээг тооцох | 2025-2028 | АҮЭБЯ | 992.7 | 2 | Монгол орны ашигт малтмалын төрлүүдийг судлан ач холбогдол бүхий төрлийг ялган үнэлгээ өгөх ГАСАМ төслийн үр дүнгийн тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар хүлээн авсан. Энэ төслөөр Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд илрүүлсэн ашигт малтмалын төрлүүдийг судлан үнэлэлт дүгнэлт өгсөн. Судалгааны үр дүнд стратегийн гэж үзэж болох ашигт малтмалыг гарал үүслийн төрлөөр нь 5 үндсэн бүлэг, 11 төрөлд ангилан ялгаж тодорхойлсон байна. | 80 | 30 | 80 |
| 28 | | | 562. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын эрэл, үнэлгээний ажил хийх, үнэлгээ өгч нөөц, баялгийн хэмжээг тооцох | 2025-2028 | АҮЭБЯ | Улсын төсөв /гүйцэтгэл 189.2 санхүүжилт 130.0/ | 5 | Өмнөд Монголын хэмжээнд алтны хүдэржилтийг судлах, улмаар Монгол орын алтны металлогений зургийг зохиох төслийн 2025 оны төсөл, төсвийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/134 дугаар тушаалаар баталсан. Төслийн үр дүнгийн тайлан зохиох суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. | 50 | 50 | 50 |
| 29 | | | 563. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх | 2025-2028 | АҮЭБЯ | - | 26 | "Сонгон шалгаруулалтын журам" батлагдсантай холбоотой сонгон шалгаруулалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн. Сонгон шалгаруулалт эхэлснээс хойш нийт 10 удаагийн сонгон шалгаруулалтын багц зарлаж, 6 удаагийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, 177,3 мян.га талбайд 35 хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож улсын төсөвт 55.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Оны эхний хагас жилд 12 удаа 484194 га талбайг хамарсан 131 талбайд сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 210826 га талбай бүхий 43 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон. Үүний үр дүнд 64.11 тэрбум төгрөгийг улсын | 100 | 100 | 100 |
| 30 | | | 564. Дархан үйлдвэрлэл, технологийн паркийн бүс нутаг дахь ашигт малтмалын сэдэвчилсэн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх | 2025-2027 | АҮЭБЯ | 0 | 0 | Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд энэ чиглэлээр судалгаа хийх ажил, түүний төсвийг суулгаж батлуулаагүй тул хэрэгжилт гаргах боломжгүй байна. | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | | 565. Бор-Өндөр үйлдвэрлэл, технологийн паркийн бүс нутаг дахь ашигт малтмалын сэдэвчилсэн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх | 2025-2027 | АҮЭБЯ | 0 | 0 | Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд энэ чиглэлээр судалгаа хийх ажил, түүний төсвийг суулгаж батлуулаагүй тул хэрэгжилт гаргах боломжгүй байна. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 32 | | 566. Шивээ Овоогийн нүүрсний ордын нөөцийг олон улсын стандартад нийцүүлэн үнэлгээг тогтоох | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 40 | Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд энэ чиглэлээр судалгаа хийх ажил, түүний төсвийг суулгаж батлуулаагүй тул хэрэгжилт гаргах боломжгүй байна.<br>Шивээ-овоогийн нүүрсний ордын талбай нь хэд хэдэн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаардаг тул тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчаж ахуйн нэгжүүд энэхүү ажлыг гүйцэтгэнэ. Энэ талаараа аж ахуйн нэгжүүд ямар нэг санал, хүсэлт гаргаагүй байна. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 33 | 3.3.1.3. Монгол Улсын зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж хэрэгжүүлнэ. | 567. Дэд бүтцийн судалгаа хийх | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | - | "Зэс хайлуулах хоёр дахь үйлдвэрийн байршил тогтоох, дэд бүтцийн нарийечилсан ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай хөрөнгийн задаргаа хийж, холбогдох мэдээллийн хамт ЭЗХЯ-нд 2025.01.30-ны өдөр хүргүүлсэн.<br>ЭЗХЯ-д зэс хайлах үйлдвэр барих төслийн өмнө хийгдсэн ажлуудын талаарх танилцуулга, мэдээллийн цахимаар хүргүүлж, ЭЗХЯ-ны судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй 2025.02.12-ны өдөр уулзалт хийсэн.<br>Эдийн засаг, хөгжлийн яаманд "Дэмжлэг хүсэх тухай" 2025.02.14-ний өдрийн 01/492 албан бичиг хүргүүлсэн. (Судалгаа, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах төсөв шийдвэрлүүлэхээр) | Х.Б | Х.Б | Х.Б |
| 34 | 3.3.1.4. Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. | 568. Цагаансуваргын зэс молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах | 2025-2028 | АҮЭБЯ | - | 10 | "Эрдэнэс цагаан суварга" ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын ордод үйл ажиллагаа явуулах ил уурхайг ашиглалтад хүлээлгэн өгөх тухай хүсэлтийг тус яаманд ирүүлсэн. Хүсэлтийн дагуу холбогдох бичиг баримтын бүрдэлтэй танилцаж, хянан дутуу баримтыг гүйцээсний дараа Улсын комисс ажиллахаар шийдвэрлэн тус компанид мэргэжил аргазүйн зөвлөмж өгч ажилласан. | 30% | 30% | 30% |
| 35 | | 569. Эрдэнэтийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих | 2025-2027 | АҮЭБЯ | 0 | 40 | Паркийн асфальт бетон хучилттай авто замын барилга угсралт 52.7%, төмөр замын барилга угсралт 96%, ус хангамж, ариутгах татуургын системийн барилга угсралт 94%, паркийн хашаа 93% гүйцэтгэлтэй ҮТП-ийн газрын хил заагийн давхцал зэргээс шалтгаалан тухайн хэсэгт баригдсан 1.7 км хашааг шилжүүлэн барьж 600 метр хашааг шинээр сунгаж барих уулын орой, өгсүүр хэсэгт 3.5 км бетон шонтой өргөст утсан хашаагаар сольж барих шаардлага үүсэн зэрэг шалтгаанаар гэрээг сунгах хүсэлтийг гүйцэтгэгчээс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-д ирүүлэхэд, гэрээг дахин сунгах боломжгүйг мэдэгдэж, ажлыг дуусгахыг шаардсан байна. Ажлын явц удаашралтай хашааны 3,4-р үеийн хавтан угсрах ажил хийгдээгүй байна.<br>ҮТП-ийн гадна цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээг барьж, байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 3 багц тендерийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ зарласан.<br>2025 онд ҮТП-ийн автозам, төмөр замыг холбосон үерийн уснаас хамгаалах байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил, ҮТП-ийн автозам болон төмөр замыг холбосон үерээс хамгаалах байгууламж барьж байгуулах, ҮТП-ийн 2-р ээлжийн төмөр [illegible] | 60% | 30% | 80 |
| 36 | 3.3.1.5. Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна. | 570. Гангийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, технологийн түвшний үнэлгээ, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 0 | 1.Гангийн цогцолборын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан бэлэн болсон. Гэвч төслийн хүчин чадлын тухайд боломжит хөрөнгө оруулагчтай хамтран тогтоох шаардлага байгаа тул тендер сонгон шалгаруулалтыг түр хугацаанд хойшлуулаад байна. 2025 оны 3-р улиралд багтаан төслийн стратегийн хамтрагч, түншийг сонгон ЗГ-т танилцуулах ба ингэснээр ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах боломж бүрдэнэ. 2025 оны 4-р улиралд багтаан ТЭЗҮ-ийг АҮЭБЯ-ний дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр батлуулахаар төлөвлөж байна.<br>2.Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар, "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс ҮТП" ХХК-аас бүрдсэн холбогдох албан тушаалтнууд 2025 оны 04 дүгээр сарын 08-15-ны өдрүүдэд БНХАУ-ын төрийн өмчит болон хувийн хэвшлийн томоохон Ган үйлдвэрлэлийн 6 компаниатай 2 талын уулзалт хийж, цаашид МУ-д Ган үйлдэрлэлийн цогцолборыг байгуулахад хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын боломжийн талаар санал солилцож, тус компаниудын Гангийн үйлдвэрлэлийн технологитой танилцсан.<br>3. Хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын дээрх компаниудаас цаашид гүнзгийрэн хамтран ажиллах сонирхолоо илэрхийлж инженер, техникийн ажилтнуудын хамт 2025 [illegible] | 10% | 10% | 10% |
| 37 | | 573. Бор-Өндөрийн жоншны баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, технологийн түвшний үнэлгээ боловсруулах | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 0 | Жонш баяжуулах үйлдвэрийн БНХАУ-д хийлгэсэн технологийн туршилтын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авсан ба уг тайланд үндэслэн "Жонш баяжуулах үйлдвэр"-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.<br>Жонш баяжуулах үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх гүйцэтгэгчийн ажлын даалгаврыг "Эрдэнэс ҮТП" ХХК боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК нь баталгаажуулан 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэгчээр Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв шалгарч хийж гүйцэтгэсэн. Мөн БОННҮ боловсруулах ажил [illegible] | 60 | 10% | 60 |
| 38 | | 575. Бор-Өндөрийн "Хорголжин төмрийн үйлдвэр"-ийн барилга байгууламж барих, тоног төхөөремж суурилуулах | 2025-2027 | АҮЭБЯ | 0 | 5 | Хугацаа болоогүй | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 3.3.1. Уул уурхай | | 576. Шохой шатаах үйлдвэрийн шинэчлэл хийх | 2025 | АҮЭБЯ | 0 | - | Шохой шатаах үйлдвэрийн ТЭЗҮ-г "Бүлжих минерал майнинг" ХХК боловсруулж ЭБМЗ-ын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Т/23-09-08 дугаар дүгнэлтээр батлагдсан. "Урьдчилсан халаагчтай эргэх зуух бүхий технологитой жилд 100 мян.тн хүчин чадалтай шохойн үйлдвэр барих" тендерийн гүйцэтгэгчийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгчээр "Сижен инженерчлэл" ХХК шалгарсан өнөөдрийн байдлаар гүйцэтгэлийн ерөнхий төлөвлөгөө болон топо зураг боловсруулагдан, архитектур төлөвлөлтийн зургын даалгавар авах хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Мөн мастер төлөвлөгөө боловсруулагдсан, гүйцэтгэгчийн зүгээс 2025 оны 05 дугаар сард захиалагчид | 30% | 30% | 30% |
| 40 | | 3.3.1.6. Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 577. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 20 | Төслийн EPC-2, EPC-3 багцын барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг тухай бүр Сангийн яаманд хүргүүлж ажилласан. 2025 оны 6 сарын 23-ны байдлаар 222 хүсэлтийг хүргүүлсэн. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар багц тус бүрийн гүйцэтгэл дараах явцтай байна. Үүнд: EPC-01 буюу Иргэний байгууламж-100%, EPC-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд – 3,.8%, EPC-03 буюу Дулааны цахилгаан станц- 24.3%, EPC-04 буюу Лицензит байгууламжууд – 8.0%, | 27.1% | 7.1% | 27.1% |
| 41 | | | 578. Газрын тос дамжуулах хоолойн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах | 2025-2026 | АҮЭБЯ | 1053.5 | 76,4 | Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах 530 км урттай дамжуулах хоолойн барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 82,0%-ийн гүцэтгэлтэй, ажлын явц дараах явцтай байна. Үүнд: Шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил- 526.446км, Хоолойн гагнуурын ажил - 517.082км, Дамжуулах хоолойн ухмалын ажил - 372.150км, Дамжуулах хоолой буулгах ажил - 368.787км, Дамжуулах хоолой булах ажил - 352.450км. | 80% | 10 | 90 |
| 42 | | 3.3.1.7. Газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ. | 579. Газрын ховор элементийн ордын нөөцийг өсгөх, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, зураг төсөл боловсруулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 5 | 1. АҮЭБ-ын яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн салбар хуралдаанаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Хөтөл улаан лити, рубидийн ордыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авч дүгнэлт тушаалыг гаргасан. 2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны едийн 08 дугаар салбар хуралдаанаар Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах, хүдрийг хөвүүлэн баяжуулах аргаар баяжуулах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авч дүгнэлт тушаалыг | 60% | 55% | 60 |
| 43 | | 3.3.1.8. Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ. | 580. Багануур, Налайх, Багахангай үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төслийг шинэчилж батлуулах | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | - | Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах чиглэлээр Төр, хувийн хэвшлийг дэмжих тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажилласан. Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран 2025.04.28-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж "Налайх ҮТП", "Багануур ҮТП", "Багахангай ҮТП"-ийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон. | 10% | 10% | 10% |
| 44 | | 3.3.1.9. Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна. | 581. Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 15 | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1.14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1.06 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 184.3 мян тонн буюу нийт шатахууны 17 хувийг эзэлж байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад /Евро-5/ ангилалын шатахууны нийт импорт 21.2 мян.тонноор өссөн үзүүлэлттэй байна.<br>Евро-5 ангиллын автобензинийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд өөрийн харьяа авто бааз болон хөдөө орон нутгийн үйлчилгээнд хэрэглэж буй түлш, шатахууны худалдан авалтын сонгон шалгаруулалтыг зарлахдаа зөвхөн экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлш сонгох шаардлага тавьж, гэрээ байгуулах, хэрэглээ, худалдан авалтыг тогтмол нэмэгдүүлэн хамтран ажиллах хүсэлтийг тус яамны ТНБД-ын 2025.01.27-ны өдрийн 02/231 дүгээр албан бичгээр "Засгийн газрын авто бааз" ТӨҮГ болон Нийтийн тээврийн бодлогын газарт тус тус хүргүүлсэн. Мөн газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын "Роснефть" компанид Евро-5 ангиллын шатахууны хэрэглээтэй | 100% | 100% | 100% |
| 45 | | | 582. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Сангийн сайдаас 2024.08.12-ны өдрийн 01/6711 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу улсын нөөцийн шатахууны агуулах барих төслийн ТЭЗҮ, зураг төсөвт шаардагдах санхүүжилтийг Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгуулах хүсэлтийг тус яамнаас АҮЭБ-ын сайдын 2024.08.23-ны өдрийн 01/248 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Үүний дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024.09.06-ны өдрийн А/08 дугаар тушаалаар холбогдох төсвийг баталсны дагуу Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв боловсруулах ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж өгөх тухай хүсэлтийг тус яамны ТНБД-ын 2024.10.04-ний өдрийн 03/590 дүгээр албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Гэвч тухайн сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж хугацаандаа гэрээ байгуулаагүйн улмаас сонгон шалгаруулалт амжилтгүй болсон. Иймд агуулахын зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах сонгон шалгаруулалтыг дахин зарлаж өгөх тухай хүсэлтийг 2025.01.15-ны өдрийн 02/99 дүгээр албан бичгээр ЭЗХЯ-нд дахин хүргүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалт дахин зарлагдаагүй байна. Үүнээс гадна агуулахын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах ажлыг | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | 3.3.1.10. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина. | 583. Алтны үндсэн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 0 | "Эрдэнэ Монгол" ХХК-ийн эзэмшиж байгаа Баянхонгор аймгийн Шинэжинст суманд байрлах MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлтэй "Баянхөндий төсөл"-ийн алтны үндсэн ордын ил уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, тус ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн ЭБМЗ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. Мөн "Эрдэнэ Монгол" ХХК-иас 2025 оны 05 дугаар сард Улсын комисс ажиллуулах тухай хүсэлтийг тус яаманд ирүүлсэн.<br>Хүсэлтийн дагуу Улсын комисс 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу төслийн талбайд Улсын комисс ажиллаж, уурхай болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.10-д "Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина" гэсэн зорилтыг хэрэгжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн болон төгрөгийн ханшийн дарамтыг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор "Алт-3" аяныг орон даяар хэрэгжүүлэхийг даалгаж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 211 дүгээр "Алт олборлолтыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолыг баталсан.<br>Дээрх тогтоолыг хэрэгжүүлэхээр алтны олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/50 дугаар тушаалаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтад ашигт | 80% | 80% | 80% |
| 47 | | 584. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн тодотгол, зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 5 | Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажилд оролцохоор өмнө сонирхлоо илэрхийлж байсан гадаад, дотоодын 13 компанитай тус яамнаас 2025 оны 02 дугаар сараас дахин холбогдож, тус үйлдвэрийн хүчин чадлыг жилд 20 тн алт, 30 тн мөнгө цэвэршүүлэх, өөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр тус үйлдвэрийг барьж байгуулах, тодорхой хугацаанд ажиллуулах саналыг хүргүүлээд байна.<br>Төслийн оролцогч талуудтай хууль эрх зүйн болон төсөл хэрэгжүүлэх хэлбэр, нөхцлийн талаар зөвшилцөх ажил хийгдэж байна.<br>Мөн Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/119 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Ажлын хэсэг нь уг төслийг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөл, бусад тавигдах шаардлагыг хангахуйц санал ирүүлсэн гадаадын 2 компани /Холбооны бүгд Найрамдах Герман Улсын Koras & EMH Group, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Temarise Gold Refining Limited/-ийн ирүүлсэн саналыг нарийвчлан судлах, техник-технологи, хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөлийг нарийвчлан тохиролцох | Х.Б | Х.Б | Х.Б |
| 48 | 3.3.1.11. Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна. | 585. Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах | 2025 | АҮЭБЯ | 0 | 0 | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Орано майнинг энгийн хувьцаат компани хооронд "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г 2025.01.17-ны өдөр байгуулсан. | 100% | 100% | 100% |
| 49 | 3.3.1.12. Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн зэс, молибдений ордын талбайн хил заагийн хүрээнд багтаж байгаа Оюут болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлж, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт | 586. Оюут ордын талбайд нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэх | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 10 | Оюутын ордод геофизикийн цахилгаан хайгуулын ажил, геофизикийн соронзон, хүндийн хүчний судалгааны ажлууд, 69 цооног 36571.6 т.м өрөмдлөгийн ажилыг хийж гүйцэтгэсэн. Нарийвчилсан хайгуулын ажил нь 2025 онд 10000 т.м өрөмдлөгийн ажил хийж бүрэн дуусна. Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ болон "Литос майнинг" ХХК-ний хооронд байгуулсан 2024 оны 07 дугаар сарын 30-ны 5/175-24 тоот "Оюутын орд (XV-022171)-ын талбайн хүдэр ба чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүний иж бүрэн судалгаа" нэртэй зөвлөх үйлчилгээний гэрээт ажил хийгдэж байна.<br>Төслийн баг Оюут ордын хүдэр ба чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүнийг судлах зорилгоор хайгуулын 5 шугамын дагуу нийтдээ 14 цооногоос нийт 470 гаруй дээж судалгаанд авч чулуулгийн болон хүдрийн эрдэслэг бүрэлдэхүүний нарийвчилсан шинжилгээнүүд (44 дээжийн Tornado, 20 дээжний Xray CT, 2 дээжний EPMA) хийсэн.<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ болон "Эрдэнийн Эрэл" ХХК-ний хооронд байгуулсан "Нарийвчилсан хайгуулын геологийн иж бүрэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх" 5/157-24 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Эрдэнийн Эрэл ХХК нь 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс Оюут ордын хайгуулын анги болон Эрдэнийн Эрэл ХХК-ийн оффис гэсэн байршлуудад гэрээт ажлыг гүйцэтгэж эхэлсэн. Гэрээт ажлыг тус компаниудын төлөөллүүдээс зөвшилцөн гаргасан ажлын гүйцэтгэлийн календарчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэлийг 2024 онд 40% (20, 20), 2025 онд 60% (30,30)-аар тусгаж санхүүжилтийг авахаар төлөвлөн ажиллаж байна.<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ болон "Газар дэлхий" ХХК-ний хооронд байгуулсан "Оюут хайгуулын талбайн төсөл" (XV-022171) 5/192-24 тоот Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу "Газар дэлхий" ХХК нь 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс Оюут | 60% | 20% | 60 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | | техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ. | 587. Стратегийн ордын талбайд хамаарах хэтийн төлөв бүхий хэсгүүдэд эрэл-хайгуулын ажил гүйцэтгэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Цахилгаан хайгуулын дундаж градиентын аргачлалаар Зээхийн голын талбайд 120 т.км ажил гүйцэтгэсэн. Хэмжилтийн цэг хоорондын зай 50м, хэмжилтийн сувгийн тоо 10 байв. Соронзон хайгуулын хэмжилтийг шугам хоорондоо 15м-ийн зайтай 365 т.км ажил хийсэн. Талбайн хэмжээнд хийсэн цахилгаан хайгуулын дундаж градиент болон соронзон хайгуулын ажлын дэвсгэр зургийн үр дүнг нарийвчлан шалгах зорилгоор цахилгаан хайгуулын поль-диполь аргачлалаар зүүнээс баруун чиглэсэн 11 т.км 4 зүсэлт хийж гүйцэтгэсэн. Цахилгаан хайгуулын анхан шатны болон эцсийн боловсруулалтыг prosys II программаар анхдагч тоон мэдээллийг татаж res2Dinv, Oasis montaj программуудыг ашиглан үр дүнг гаргасан. 50 т.км геологийн маршрутын ажил хийж 6 дээжлэлт хийгдсэн. Геофизикиийн соронзон хайгуулын ажил Хөх Асгатын талбайд шугам хооронд 50 метрээр 135 т.км, Зээхийн голын талбайд шугам хооронд 15 метрээр 365 т.км, Ундрахын талбайд шугам хооронд 50 метрээр 130 т.км, Оюутын ордод шугам хооронд 15 метрээр 370 т.км ажил гүйцэтгэсэн. Нийт 1000 т.км буюу 100%-ийн биелэлттэй. Оюутын болон Зээхийн голын талбайд 15 метрээр нарийвчлалтай хэмжилт хийснээр хүдрийн биетийн структур, хагарал ан цавыг нарийвчлан тодорхойлсон. Соронзон хайгуулын ажлыг орд, илрэл, хэтийн төлөвтэй талбайнуудад … | 100% | 100% | 100% |
| 51 | | 3.3.1.13. Нүүрс-химийн технологийг эзэмших, хүний нөөцийг бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, үстөрөгч гарган авна. | 588. "Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр"-ийн төслийг хэрэгжүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | 5 | "Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг ЭБМЗ-өөр 2023.12.27-ны өдөр батлагдаж тус төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг АҮЭБЯ-ны сайдын 2025 оны 04 сарын 01-ний өдрийн А/72 тоот тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсэг 2025 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан бүтээгдэхүүн, зах зээлийн судалгаа, технологийн түвшний үнэлгээ, технологийн боломжит хувилбаруудыг тодорхойлох, технологи нийлүүлэгчдийн судалгаа болон уулзалт хэлэлцээр, хамтран ажиллах, туршилтын дээж илгээх, хагас үйлдвэрлэлийн туршилтыг явуулах, технологи нийлүүлэгчийн сонголтыг хийх зэрэг … | 5% | 5% | 5% |
| 52 | 3.3.2. Боомтын шинэчлэл, тээвэр, логистик | 3.3.2.6. Зам, тээврийн салбарт дэвшилтэт техник, технологи, инновац, дижитал шилжилтийг нэвтрүүлж, тээвэрлэлтийн аюулгүй, найдвартай байдлыг хангасан тээврийн мэдээллийн нэгдсэн цахим системийг хөгжүүлнэ. | 624. Автомашинаас үүссэн аюултай хог хаягдлыг (шингэн болон хатуу) дахин боловсруулах үйлдвэр байгуулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Тайлант хугацаанд буюу 2025 оны эхний хагас жилийн байдлаар ЭБМЗ-ийн Аж үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар "Эрч кемикал" ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах "Ашигласан тосноос дизель түлш боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ(хүчин чадал: 10 тн/хоног)-ийг хэлэлцэж, хүлээн авсан. Мөн ЭБМЗ-ийн Аж үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүсэлт ирүүлсэн "Розмарин" ХХК-ийн Орхон аймгийн Баян-Өндөр суманд байгуулагдах "Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ(хүчин чадал 1600тн/жил аюултай хог хаягдал)-д шинжээч … | 10% | 10% | 10% |
| 53 | 3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал | 3.3.3.7. Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ. | 711. Олон улсын атомын энергийн агентлагийн зөвлөмж болгосны дагуу цөмийн эрчим хүчний станцын дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай үндсэн 19 нэрийн суурь судалгааны … | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас санал ирүүлээгүй болно. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 54 | | 3.3.3.15. Эрчим хүчний аюулгүй байдал, чухал ашигт малтмалын салбарт Монгол Улсын байр суурь, оролцоо, хамтран ажиллах хоёр болон гурван талт механизмыг … | 725. Эрчим хүчний аюулгүй байдал, чухал ашигт малтмалын салбарт хамтран ажиллах хоёр болон гурван талт механизмыг хөгжүүлэх | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 55 | 3.3.4. Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр | 3.3.4.23. Чанар, стандартын шаардлага хангасан бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | … Уул уурхайн ордыг түшиглэн химийн бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, бордооны үйлдвэр … | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | Х.Б |
| **3.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт** | | | | | | | | | | | | |
| 56 | | 3.4.2.1. Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна. | 971. Хүлэмжийн хийн бүртгэл, тооллого, тайлагналын асуудлаар эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, зам, тээвэр, аж үйлдвэр, уул уурхай, хог хаягдлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Хүлэмжийн хийн бүртгэл, тооллого, тайлагналын асуудлаар салбарын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор салбар тус бүрийн хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон цаашид шинээр үүсэх тооцооллыг хийх хэрэгцээ шаардлага бий болсон бөгөөд энэ хүрээнд GIZ байгууллагаас аж үйлдвэр, эрчим хүчний хэрэглээний салбарт дотоодын зөвлөх авч ажиллуулан 2020 оноос өнөөг хүртэлх хүлэмжийн хийн ялгарал болон 2035 он хүртэл хугацаанд шинээр үүсэх тооцоолол, мэдээлэл гаруулахаар "ЭРДЭНЭС ҮТП" ХХК, "ЭРДЭНЭС АЛТ РУСУРС" … | Х.Б | Х.Б | Х.Б |
| 57 | | | 972. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нүүрстөрөгчийн дотоодын арилжаанд оролцох зохицуулалтыг бий болгох, салбар дундын зохицуулалтаар хангах хууль, журам, аргачлалыг … | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | 1 | Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нүүрстөрөгчийн дотоодын арилжаанд оролцох зохицуулалтыг бий болгох, салбар дундын зохицуулалтаар хангах хуулийн төсөлд санал өгч холбогдох байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээний дагуу БОУАӨЯ-аас зохион байгуулсан "Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585-2016" болон Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээллэх журам"-ыг шинэчлэх ажлын хэсгийн хэлэлцүүлэгт оролцож санал боловсруулж хүргүүлсэн. | Х.Б | Х.Б | Х.Б |
| 58 | 3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт | 3.4.2.2. Уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх … | 974. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн 2020-2024 оны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үндэсний зорилтыг шинэчлэн хэрэгжилтийг хангах | 2026-2027 | АҮЭБЯ | 0 | - | Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх "Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН)"-ийн зорилтыг ахиулан шинэчлэх дэд ажлын хэсгүүдийн үр дүнг танилцуулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, тэсвэртэй, дасан зохицсон нийгэм, эдийн засгийн салбаруудыг бий болгох, иргэд олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх, аж ахуйн нэгж байгууллагын хөгжлийн зорилтыг салбар бүрт уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулах тэргүүлэх чиглэл, арга хэмжээний төслүүдийг танилцуулах … | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | | 3.4.2.4. Говийн болон ус хангамжийн дутагдалтай бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ. | 983. "Цагаан цав" ус хангамжийн төслийг хэрэгжүүлэх | 2025-2028 | АУЭБЯ | 0 | - | "Цагаан Цав" газрын доорх усны ордод 1977 онд гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийгдэж, усны нөөцийг үйлдвэрлэлийн C1 зэрэглэлийн түвшинд нийт ундаргыг 800 л/сек-ээр тогтоосон байна. Тус батлагдсан нөөцөөс 220 л/сек усыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайг түшиглэсэн Үйлдвэрлэл, технологийн паркийн төслүүдийн ус хангамжид хэрэглэхээр тооцож, ирээдүйд "Хэрлэн Тооно" төсөл хэрэгжих үед уялдах боломжтойгоор төлөвлөж байна.<br>Ингэснээр Монгол Улсын нийгэм-эдийн засгийн ирээдүйн болон алс хэтийн төлөв, хөгжлийн стратегийн бодлогод томоохон ач холбогдол бүхий говийн бүсэд орших эрчим хүчний зориулалттай болон коксжих нүүрсний уурхайнуудын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэж, Монгол Улс болон бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг өндөр түвшинд хүргэх боломжийг бүрдүүлнэ. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад "Хайдродизайн" ХХК шалгарсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гэрээг байгуулан ажиллаж байна. Төслийн гүйцэтгэл 20% | 20% | 20% | 20% |
| 60 | | 3.4.2.8. Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгана. | 992. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу тогтмол чанартай хийлгэх | 2025-2028 | АУЭБЯ | 0 | Техникийн 9773, биологийн 2549 | Техникийн нөхөн сэргээлт 403.6 га - 1388.59 сая.төгрөг.<br>Биологийн нөхөн сэргээлт 252.2 га - 1446.97 сая.төг (2024 оны 62 тайлангийн хүрээнд) | Х.Б | Х.Б | Х.Б |
| 61 | 3.4.3. Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар | 3.4.3.3. Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1000. Агаар бохирдуулагч үйлдвэр, эх үүсвэрүүдэд экологийн стандарт тогтоож, мөрдүүлэх | 2025-2028 | АУЭБЯ | 0 | - | 1. Эрчим хүчний сайдын 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар "Сайжруулсан шахмал түлш" MNS 5679:2022 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрт "0" давхаргын эрчим хүчний зориулалттай 2000 тонн нүүрсийг баяжуулж, Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрт нийт 400 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэсэн. Тус шахмал түлш болон баяжуулсан нүүрснээс дээж авч, итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлэн шинжилгээ, туршилтын ажлыг гүйцэтгэж байна. Судалгаа, туршилтын ажлын явц 60% хувь байна.<br>2. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Агаарын бохирдол-хүн амын эрүүл мэнд (Амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх), Стандарт, хяналт (Зуух, түлшний технологи)", "Эрх зүйн орчин, бодлого шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага", Зуух, түлшний технологийн шийдлүүд" сэдвээр дөрвөн цуврал | 60% | 60% | 60% |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **4.1. Хүний эрх, эрх чөлөө** | | | | | | | | | | |
| 62 | 4.1.1. Хүний эрх | 4.1.1.13. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргах шийдвэрт тухайн харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг тусгана. | 1045. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргах шийдвэрт тухайн харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг тусгах | 2025-2028 | АУЭБЯ | 0 | - | Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулахаар холбогдох судалгааг хийж байгаа бөгөөд хуулийн төсөл боловсруулсны дараа хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс санал авна. | Х.Б | Х.Б | Х.Б |
| **4.3. Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл** | | | | | | | | | | |
| 63 | 4.3.1. "E-Mongolia"-блокчейн-Цахим засаглал | 4.3.1.3. Мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад салбарт өргөнөөр нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ. | 1179. Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх | 2025-2027 | Эдийн засаг, хөгжлийн яам | 0 | - | Хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | Х.Б |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвах ба амар тайван нийгэм | | | | | | | | | | |
| 64 | 4.4.2. Гадаад бодлого | 4.4.2.5. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана. | 1270. Бүгд Найрамдах Энэтхэг Улстай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, тус улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2025-2026 | АҮЭБЯ | 0 | - | Төслийн EPC-2, EPC-3 багцын барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг гаалийн түр гормиоор оруулах, өрөнхий гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг тухай бүр Сангийн яаманд хүргүүлж ажиллав. 2025 оны 6 сарын 23-ны байдлаар 222 хүсэлтийг хүргүүлсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2025 оны 06 дугаар сарын 01-ний вдрийн байдлаар багц тус бүрийн гүйцэтгэл дараах явцтай байна. Үүнд: EPC-01 буюу Иргэний байгууламж-100%, EPC-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд – 3,.8%, EPC-03 буюу Дулааны цахилгаан станц- 24,,3%, EPC-04 буюу Лицензит байгууламжууд – 8,0%, төслийн гүйцэтгэл нийлбэр дүнгээр 27,1%-тай байна.<br>2025 оны 05-р сарын 15-ны өдөр Сангийн сайд Б.Жавхлан, АҮЭБ-ийн сайд Ц.Туваан нар БНЭУ-ын Гадаад харилцааны яамны Тусгай нарийн бичгийн дарга бөгөөд Санхүүгийн зөвлөх Анураг Агарвал тэргүүтэй Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Сангийн яам, ЭКСИМ банкны төлөөлөгчидтэй уулзаж, Монгол газрын тос боловсруулах [illegible] | 30% | 30% | 30% |
| 65 | | | 1275. Канад Улстай хэрэгжүүлж буй "Иж бүрэн түншлэл"-ийн харилцааг бэхжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Канад улстай хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын хөрөнгө оруулалтын (Prospectors and Developers Association of Canada -PDAC) PDAC уулзалтанд Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци (МУҮҮА) хувийн хэвшлийн төлөөллүүд хамтран Монголын үзэсгэлэнгийн талбайг ажиллуулж, Монгол Улсын эрдэс баялгийн салбарын томоохон төсөл, боломжуудыг дэлхийн хөрөнгө оруулагчдад танилцуулдаг. Канад Улстай уул уурхай, эрдэс баялгийн салбарт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан тэргүүтэй УИХ, Засгийн газрын гишүүд 2025 оны 2 дугаар сарын 28-аас 3 дугаар сарын 08-ны өдрүүдэд Канадын Торонто хотноо зохион байгуулагдсан "Олон улсын уул уурхайн (PDAC-2025)" чуулга уулзалтад оролцсон. Чуулга уулзалтын үеэр "Олон улсын уул уурхайн сайд нарын дээд хэмжээний уулзалт" болон Монгол Улсын уул уурхайн салбарын бодлого, чиглэл, үйл ажиллагааг Канадын хөрөнгө оруулагчдад сурталчлах зорилго бүхий "Mongolian Day" арга хэмжээг зохион байгуулж Монгол Улсын Засгийн газраас эрдэс баялаг, аж үйлдвэрийн салбарт баримталж буй бодлого, чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн талаар танилцуулсан. Мөн Канадын хайгуулч, олборлогчдын холбооны гүйцэтгэх захирал, Канадын Эрчим хүч, байгалийн нөөцийн туслах, дэд сайд, Торонтогийн хөрөнгийн биржи | 100% | 100% | 100% |
| 66 | | 4.4.2.15. Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үр өгөөжийг дээшлүүлнэ. | 1306. Чухал ашигт малтмалын салбарт гуравдагч хөршүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллах | 2025-2028 | АҮЭБЯ | 0 | - | Чухал ашигт малтмалын салбарт гуравдагч хөршүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллах дараах улс орнуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1. МУ болон БНСУ-ын хамтарсан ховор металл/чухал ашигт малтмал/-ын хамтарсан судалгааны төв байуулах асуудлаар Солонгос Улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрээр "Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-ыг түшиглэн төслийг 2023-2027 онд хэрэгжүүлж байна. Өнөөдрийн байдлаар хамтарсан судалгааны төвийн лаборторийн байрыг шинэчлэн засварлаж тоног төхөрөөмжийг суурилуулах ажил 90%-тай хийгдэж байна. Мөн тус лабораторит ажиллах Монгол инженерүүдийг Солонгос Улсад богино хугацааны сургалтад хамруулсан.<br>2. Франц Улстай чухал ашигт малтмалын нэг төрөл болох литийн судалгааг Монгол орны баруун хэсэгт хийхээр Францын Геологийн алба, Монгол Улсын Үндэсний геологийн алба хоооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна.<br>3. МУ-ын Засгийн газар, Бахрейны Хаант Улсын Засгийн газар болон Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Дабигийн Эмират хооронд ашигт малтмалын нөөцийг өсгөх геологийн судалгаа, эрэл, хайгуулын салбарт хамтран ажиллах хэлэлцэц хийсэн. Хэлэлцээний хүрээнд дээрх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна.<br>4. Оманы хаант Улс, Узбекстан Улс, ИБУИНВУлс, ОХУ зэрэг улсуудтай чухал ашигт малтмалын чиглэлээр геологийн судалгааны ажил хамтран хийх талаар харилцан санал солилцон ажиллаж байна. | 80% | 80% | 80% |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ХЯНАСАН:
ХШҮДАГ-ЫН ДАРГА Б.ӨНӨМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ Ц.ТЭМҮҮЖИН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 30-ний өдөр

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилт, зорилго, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2025 оны 06 **дугаар** сарын байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар 9 зорилгын 39 зорилтын 66 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтад авсан нийт 66 төсөл, арга хэмжээнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 41, бусад яам, агентлаг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшилтэй 25 арга хэмжээнд тус яам хамтран хэрэгжүүлэгчээр оролцон ажиллаж байгаа ба хэрэгжилт **50.17** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Бүсийн төрөлжсөн хөгжлийн бодлогын хүрээний 10 зорилтын 16 арга хэмжээний биелэлт 30.5 хувь,
- Хүний хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 50.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын 23 зорилтын 43 арга хэмжээний биелэлт 57.4 хувь,
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 4 зорилтын 5 арга хэмжээний биелэлтийг 70.0 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний товчоо

| Зорилго | Зорилт | Төсөл, арга хэмжээ | Үнэлгээ /%/ | | | | | ДУНДАЖ ДҮН /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 85%-аас дээш | 60-84% | 30-59% | 0-29% | Хугацаа болоогүй | |
| НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 10 | 16 | 1 | 1 | 3 | 5 | 6 | 30.5 |
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 2 | 2 | - | 1 | 1 | - | - | 50.0 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | 23 | 43 | 5 | 10 | 8 | 5 | 15 | 57.4 |
| ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | 4 | 5 | 1 | 1 | 1 | - | 2 | 70.0 |
| **НИЙТ** | **39** | **66** | **7** | **13** | **13** | **10** | **23** | **50.17** |

**Дөрөв. Дүгнэлт.**

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн хэрэгжүүлэгчээр тусгагдсан 41 арга хэмжээний дундаж гүйцэтгэл 2025 оны 06 дугаар сарын байдлаар **50.17%-тай**, өссөн дүн **39.57%-тай** дүгнэгдсэн бол хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан 25 арга хэмжэээний биелэлт **57.0%-тай,** өссөн дүн **56%-тай** дүгнэдсэн байна. Үүнд:

- Үр дүнтэй буюу 90 хувийн гүйцэтгэлтэй - 1, 100 хувийн гүйцэтгэлтэй - 6 арга хэмжээ
- Үр дүн хүлээгдэж байгаа буюу 60 хувийн гүйцэтгэлтэй – 4, 65 хувийн гүйцэтгэлтэй – 1, 70 хувийн гүйцэтгэлтэй – 1, 80 хувийн гүйцэтгэлтэй - 5 арга хэмжээ
- Үр дүн хангалтгүй буюу 30 хувийн гүйцэтгэлтэй – 8, 50 хувийн гүйцэтгэлтэй – 6 арга хэмжээ
- Үр дүн гараагүй буюу 5 хувийн гүйцэтгэлтэй – 1, 10 хувийн гүйцэтгэлтэй – 8, 20 хувийн гүйцэтгэлтэй – 1 арга хэмжээ
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – 24 арга хэмжээ тус тус үнэлэгдсэн.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх.
2. Зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгойг тухай бүр цуглуулж тайланд хавсаргах;
3. Тайланг тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх;

4. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах.

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХШҮДАГ-ЫН ДАРГА Б.ӨНӨМӨНХ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ Ц.ТЭМҮҮЖИН